



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
<http://www.mfa.gov.mn>

2017.01.05 № 09/39

танай _____ -ны № _____ -т


Г ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН Г
АЛБАНЫ ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

“Дипломат болон албан/тусгай паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Балба Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан бөгөөд уг хэлэлцээр нь 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх юм. Хэлэлцээрийн дагуу Монгол Улсын болон Балба Улсын дипломат болон албан/тусгай паспорт эзэмшигч иргэд 90 харилцан визгүй зорчино.

Хэлэлцээрийн хуулбарыг хавсралтаар хүргүүлэв. Холбогдох газар, нэгждээ мэдэгдэхийг хүсье.

ОЛОН УЛСЫН ГӨРЭЭ,
ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ А.ТӨМӨР

Ч.Булгансүрэн
Холбогдох яаманд
авгуулах
2017.01.05



095639

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН/ТУСГАЙ ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БАЛБА УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Балба Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч Талууд" гэх,

Хоёр улсын хоорондын найрсаг харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн, тэдгээрийн албаны шугамаар харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

1. Хүчин төгөлдөр дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч Балба Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш ер (90)-ээс дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох болон зорчих эрхтэй бөгөөд эдгээр иргэд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх болон бусад хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэхгүй.

2. Балба Улсын хүчин төгөлдөр дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч бөгөөд Монгол Улсад дипломат албан үүрэг гүйцэтгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрэх Балба Улсын иргэн, мөн түүний гэр бүлийн гишүүн болох дипломат болон албан/тусгай паспорт эзэмшигч иргэд Монгол Улсад 90 хүртэл хоног визгүй нэвтрэх болон зорчиж болно. Энэхүү хугацааг Бээжин дэх Балба Улсын ЭСЯ-наас тавьсан хүсэлтийг үндэслэн албан үүргээ гүйцэтгэж дуусгах хүртэл хугацаагаар сунгаж болно.

2 дугаар зүйл

1. Хүчин төгөлдөр дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч Монгол Улсын иргэд Балба Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш ер (90)-ээс дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох болон зорчих эрхтэй бөгөөд эдгээр иргэд Балба Улсад хөдөлмөр эрхлэх болон бусад хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэхгүй.

2. Монгол Улсын хүчин төгөлдөр дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч бөгөөд Балба Улсад дипломат албан үүрэг гүйцэтгэх зорилгоор Балба Улсын хилээр нэвтрэх Монгол Улсын иргэн, мөн түүний гэр бүлийн гишүүн болох дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч иргэд Балба Улсад 90 хүртэл хоног визгүй нэвтрэх болон зорчиж болно. Энэхүү хугацааг Шинэ Дели дэх Монгол Улсын ЭСЯ-наас тавьсан хүсэлтийг үндэслэн албан үүргээ гүйцэтгэж дуусгах хүртэл хугацаагаар сунгаж болно.

3 дугаар зүйл

1. Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт нөгөө талын дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч иргэдийг чөлөөтэй, саадгүй буцаан нэвтрүүлэхийг зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохиролцогч хоёр улсын дипломат эсхүл албан/тусгай паспорт эзэмшигч иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг сахих үүрэгтэй.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч талуудын эрх бүхий байгууллага үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн дагуу визээс чөлөөлөгдсөн аливаа иргэнийг хилээр нэвтрүүлэх болон зорчих зөвшөөрөл олгохоос татгалзах эсхүл дуусгавар болгох эрхтэй.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм арга хэмжээ авах болон цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

2.Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал шинэ паспорт нэвтрүүлэх тохиолдолд тэрхүү шинэ, эсхүл өөрчлөлт оруулсан паспортын загварыг шинэ паспорт нэвтрүүлэх болон паспортод өөрчлөлт оруулахаас доод тал нь гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хүргүүлнэ.

7 дугаар зүйл


Энэхүү хэлэлцээрт Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно

8 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд таван (5) жилийн хугацаанд хүчинтэй байна. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал дипломат шугамаар хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хэлэлцээрийг цуцлах тухайгаа зургаан (6) сарын өмнө бичгээр хүргүүлэх хүртэл тус хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр байна.

Энэхүү хэлэлцээрийг Катманду хотноо 2016 оны 12 дугаар сарын 19 -ны өдөр монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ
БАЛБА УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

